



**ТӨРИЙН ӨМЧИЙН БОДЛОГО,
ЗОХИЦУУЛАЛТЫН ГАЗРЫН
ТОГТООЛ**

2022 оны 05 сарын 13 өдөр

Дугаар 199

Улаанбаатар хот

**Үндсэн хөрөнгө бүртгэх зөвшөөрөл олгох
тухай**

Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 11 дүгээр зүйлийн 8, 25 дугаар зүйлийн 1 дэх хэсэг, Засгийн газрын 2008 оны “Төрийн болон орон нутгийн өмчийн талаар авах зарим арга хэмжээний тухай” 148 дугаар тогтоолын 1.а дах заалт, Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын 2019 оны 271 дүгээр тогтоолоор баталсан “Төрийн болон орон нутгийн өмчид эд хөрөнгө олж авах, бүртгэх, данснаас хасах, шилжүүлэх журам”-ын 4.3 дахь заалтыг тус тус үндэслэн ТОГТООХ нь:

1. Азийн хөгжлийн банкны “Хөдөлмөр эрхлэх ур чадварыг дээшлүүлэх төсөл”-ийн санхүүжилтээр барьж ашиглалтад оруулсан 2 нэрийн, нийт 83,420,946.00 (наян гурван сая дөрвөн зуун хорин мянга есөн зуун дөчин зургаан) төгрөгийн үнэ бүхий хавсралтад заасан хөрөнгийг Баянхонгор аймгийн Политехник коллежид эзэмшүүлж, үндсэн хөрөнгөд бүртгэхийг зөвшөөрсүгэй.

2. Боловсрол, шинжлэх ухааны яамны Төрийн нарийн бичгийн дарга Л.Цэдэвсүрэн, Баянхонгор аймгийн Политехник коллежийн захирал П.Бат-орших нарт дор дурдсан арга хэмжээ авч ажиллахыг даалгасугай:

2.1. Хөрөнгө хүлээлцэх ажлыг компанийн өмч хамгаалах Байнгын зөвлөлийн хяналт дор зохион байгуулах;

2.2. Хөрөнгийн хөдлөлийг зохих хууль тогтоомж, журмын дагуу нягтлан бодох бүртгэл, тайланд тусган, “Төрийн болон орон нутгийн өмчийн удирдлагыг мэдээлэлжүүлэх систем”-д бүртгэх;

2.3. Арга хэмжээний биелэлтийг 2022 оны 2 дугаар улиралд багтаан ирүүлэх.

3. Энэ тогтоолын биелэлтэд хяналт тавьж ажиллахыг Төрийн өмчийн бүртгэл, ашиглалтын хэлтэс (Д.Нарангэрэл)-т үүрэг болгосугай.

ДАРГА

Б.ЦЭНГЭЛ

ТӨРИЙН ӨМЧИЙН БҮРТГЭЛ,
АШИГЛАЛТЫН ХЭЛТСИЙН ДАРГА *Д. Нарангэрэл* Д.НАРАНГЭРЭЛ

Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын
2022 оны 10 дугаар сарын 1-ны өдрийн
199 дугаар тогтоолын хавсралт

**БАЯНХОНГОР АЙМГИЙН ПОЛИТЕХНИК КОЛЛЕЖИЙН ӨМЧИД БҮРТГЭХ ХӨРӨНГИЙН
ЖАГСААЛТ**

Д/д	Хөрөнгийн нэр	Улсын комиссын актын дугаар	Тоо, хэмжээ	Нэг бүрийн үнэ	Нийт балансын дүн
			Ширхэг		
1	Авто засварын дадлагын барилгын гадна тохижилт	2020-07-23	1	26,108,690.00	26,108,690.00
2	Авто засварын дадлагын барилгын гадна шугам сүлжээ	2020/22	1	57,312,256.00	57,312,256.00
Нийт дүн					83,420,946.00 (наян гурван сая дөрвөн зуун хорин мянга есөн зуун дөчин зургаан)